



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/27

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудлын үйл  
ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох,  
хүчингүй болгох тухай

Монгол улсын Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5. дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ - Зочид буудалд тавих ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандартын шаардлагыг хангасан, тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Аялал жуулчлал дэн буудал. Ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандартын шаардлагыг хангасан, тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Хүннү ХХК-ийн “Хүннү палас” зочид буудлын 17/060, Эпос зантуул ХХК-ийн “Эпос” зочид буудлын 17/042, Корпорейт хотел ХХК-ийн “Корпорейт” зочид буудлын 17/056, МЦ ХХК-ийн “Хаанчлал” дэн буудлын 17/030, Дөл тулгуур ХХК-ийн “Таван од” дэн буудлын 17/034, Гүн нуур гэрэл ХХК-ийн “Зочин” дэн буудлын 17/053, Ачнууд ХХК-ийн “Санни” дэн буудлын 16/164, Агь халиун ББН-ийн “Агь” дэн буудлын 14/017 гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

1150500085

4. Зөвшөөрөл авсан байгууллагуудтай гэрээ байгуулж үр дүнг тоцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Үйлчилгээний байгууллага, стандарт хариуцсан мэргэжилтэн /Б.Амар/-д үүрэг болгосугай.

6. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2018 оны 09 сарын 11 өдрийн 1/27 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2018.04.11

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Хүннү ХХК	2084538	Хүннү палас	СБД-ийн 11-р хороо Их тойруу 13
2	Эпос зантуул ХХК	5072646	Эпос	СБД-ийн 1-р хороо Чин Ван Чагдаржавын гудамж 19/2
3	Корпорейт хотел ХХК	5124026	Корпорейт	СБД-ийн 1-р хороо Чингисийн өргөн чөлөө 9-2
4	Санжат ХХК	2548852	Бүрэн	БГД-ийн 12-р хороо Хасбаатарын гудамж 12
5	Түм арвижих ХХК	5104823	Дотно	ЧД-ийн 3-р хороо Дотно төв 5-3
6	Дунфу ХХК	6256759	Мөнгөн тойг	БГД-ийн 5-р хороо ЭТӨЧ 99 тоот

--ooOoo--

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2018 оны 04 сарын 11  
өдрийн А/2.7 дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт

1117139285  
УОА0453 5284325

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2018.04.11

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	МЦ ХХК	2056577	Хаанчлал	БЗД-ийн 13-р хороо ЭТӨЧ 111
2	Дөл тулгуур ХХК	5574293	Таван од	СХД-ийн 6-р хороо ханын материал 58в байрны баруун талд
3	Гүн нуур гэрэл ХХК	5060508	Зочин	ЧД-ийн 14-р хороо Хайлааст 12-200
4	Ардууш өв ХХК	6287743	Булган	СХД-ийн 17-р хороо Москвагын 45-р байр
5	Гантигт этүгэн ХХК	6251862	Эрмүүн	БГД-ийн 14-р хороо 3-р хороолол Энэбишийн өргөн чөлөө 19а
6	Өөдлөх жим ХХК	5283442	Байгаль	БГД-ийн 4-р хороо 2-р хороолол 018-р байр
7	Ачнууд ХХК	2854341	Санни	БЗД-ийн 16-р хороо Дандарын гудамж Санни төв
8	Агь халиун ББН	2247011	Агь	БГД-ийн 4-р хороо 2-р хороолол 10-23
9	Муда гуга ХХК	5832012	Лида	БЗД-ийн 4-р хороо Доржийн гудамж 48-3

--ooOoo--